

**МОНГОЛ УЛС: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САР
ТУТМЫН ТОЙМ**

2015.08

Үзүүлэлтүүд:

ДНБ 3%	ГШХО 7-р сард 99.4 сая ам.доллар	Төсвийн тэнцэл (769.2) тэр бум төгрөг	Инфляци 6.6%	Чанаргүй зээл 865.5 тэрбум төгрөг	Валютын нөөц 1707 сая ам.доллар
Өсөлтөнд ХАА салбар 9.2%, аж үйлдвэр, барилгын салбар 12.1%, үйлчилгээний салбар 3%-иар тус тус өссөн нь нөлөөлөв.	Цэвэр ГШХО 7-р сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 35.5 сая ам.доллараар, өмнөх сараас 33.8 сая ам.доллараар тус тус өсч 99.4 сая ам.доллар болов.	Төсвийн орлого 3.57 их наяд төгрөг, зарлага 4.34 их наяд төгрөг, тэнцэл 769.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.	Өмнөх сараас 0.1 хувь, оны эхнээс 3.4 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 6.6 хувиар өслөө.	Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 40.8 тэрбум төгрөг буюу 5%-иар өсч 865.5 тэрбум төгрөгт хүрэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээл 7.3% .	Монголбанкны валютын нөөц өмнөх сараас 1.3 хувь буюу 22 сая ам.доллараар өсч 1707 сая ам.долларт хүрэв.



Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш

1990.48



Орон сууцны үнийн индекс

1.117

Өмнөх сараас 0.503%-иар, оны эхнээс 5.584%-иар тус тус буурлаа.



Монголбанкны бодлогын хүү

13%




Монголын анхдугаар Богд Өндөр гэгээн Занабазарын мэндэлсний 380 жилийн ойг тохиолдуулан 100 жилийн өмнө Их хүрээнд тэмдэглэдэг байсан Даншиг наадмыг сэргээн Монголын бурхан шашны сүм хийдүүд, НЗДТГ-тай хамтран Улаанбаатар хотноо Хүй долоон худагт 8-р сарын 8, 9-ний өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүллээ.

Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, оны эцсийн байдлаар хүснэгтээр үзүүлээ.

Эх сурвалж: УСХороо



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд (Мянган ам.доллар, тонн)


Голлох бүтээгдэхүүн	2012 он		2013 он		2014 он	
	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар
Чулуун нүүрс	20574	1 880 396	18 194	1 116 153	1 106	850 615
Төмрийн хүдэр	6415	532 509	6725	654 333	8 338	448 378
Зэсийн баяжмал	575	838 780	650	948 951	1 378	2 675 636
Нийт	27564	3 251 685	25 569	2 719 437	10 822	3 874 629

Эх сурвалж: УСХороо

Монгол Улс Дэлхийн II дайны төгсгөл 1945 оны чөлөөлөх дайнд Зөвлөлтийн улаан армитай хамт оролцож ялалт байгуулсаны түүхт 70 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүллээ.


ДНБ

ДНБ 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2015 оны эхний хагас жилд 7.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 205.6 тэрбум төгрөг буюу 3 хувиар өслөө. Үүнд ХАА-н салбар 9.4 хувь, аж үйлдвэр, барилгын салбар 12.1 хувь, үйлчилгээний салбар 3 хувиар тус тус өссөн нөлөөлжээ.



Төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ наймдугаар сард 3.57 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх зээлийн хэмжээ 4.34 их наяд төгрөг, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 769.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 616.2.7 тэрбум төгрөг буюу 5 дахин өссөн байна.




Валютын ханш

Наймдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 1990.48 төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 128.31 төгрөг буюу 6.9 хувь, өмнөх сараас 13 төгрөгөөр буюу 0.6 хувиар тус тус суларсан байна.



Инфляци

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2015 оны наймдугаар сард өмнөх сарынхаас 0.1%, оны эхнээс 3.4%, өмнөх оны мөн үеийнхээс 6.6%-иар өслөө. Индекс өмнөх сарынхаас 0.1%-иар өсөхөд боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 23.1 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.



* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж УСХ, МБ

Гадаад валютын нөөц


Гадаад валютын улсын албан нөөц 2015 оны 8-р сарын байдлаар 1707 сая ам.доллар болов. Энэ нь өмнөх сараас 1.3% буюу 22 сая ам.доллараар, өнгөрсөн оны мөн үеэс 26.5 хувь буюу 358 сая ам.доллараар, оны эхнээс 3.5% буюу 57 сая ам.доллараар тус тус өссөн байна. Валютын нөөц сүүлийн 3 сар дарааллан өсөөд байна.



* Эх сурвалж Монголбанк

MSE-20 индекс

Үнэт цаасны арилжаагаар наймдугаар сард 691.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 22.4 сая ш үнэт цаас арилжигдсан нь өмнөх оны мөн үеийнхээс гүйлгээ 556.3 тэрбум төг буюу 5.1 дахин, арилжигдсан үнэт цаас 14.7 сая ш буюу 39.7%-иар буурч, мөн ТОП-20 индекс 13268.5 болж, өмнөх сарынхаас 950.5 нэгжээр буурчээ. Хөрөнгийн бирж үйл ажиллагаа явуулж байгаа ХК-иудын үнэт цаасны нийт үнэлгээ 1.3 их наяд төг болж, өмнөх сарынхаас 64.1 тэрбум төг буюу 4.8 хувиар буурчээ.



*Монголын хөрөнгийн бирж

Мөнгө

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2015 оны наймдугаар сарын эцэст 10 их наяд төгрөг болж, өмнөх сараас 100.9 тэрбум төгрөг буюу 1%-иар өсч, өмнөх оны мөн үеэс 171.7 тэрбум төгрөг буюу 1.7 %-иар буурчээ. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө наймдугаар сард 774.7 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 15.4 тэрбум төгрөг буюу 2%-иар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 105.7 тэрбум төгрөг буюу 12%-иар буурсан байна.



Хадгаламж

Нийт хадгаламж 2015 оны 8-р сард сард 7.22 их наяд төгрөг болж, өмнөх сараас 23 тэрбум төгрөг буюу 0.3 хувиар өссөн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 625.4 тэрбум төгрөг буюу 3.6 хувиар өссөн үзүүлэлт юм. Ийнхүү өмнөх сараас нийт хадгаламж өсөхөд төгрөгийн хадгаламж 1.5 хувиар буюу 78.4 тэрбум төгрөгөөр бууж, валютын хадгаламж 5 хувиар буюу 101.4 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөллөө.



Зээл

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2015 оны наймдугаар сарын байдлаар 11.8 их наяд төгрөг болж, өмнөх сараас 152 тэрбум төгрөг буюу 1.3%-иар, өмнөх оны мөн үеэс 497.6 тэрбум төгрөг буюу 4%-иар тус тус буурлаа. Харин чанаргүй зээлийн хэмжээ 865.5 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 5% (40.8 тэрбум төгрөг)-иар, өнгөрсөн оны мөн үеэс 39.6% (245.5 тэрбум төгрөг)-иар тус тус өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 7.3%-ийг эзэлж байна.



Ипотекийн зээл

Наймдугаар сард нийт 1106 зээлдэгчид 60.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 73 949-д хүрч ипотекийн зээлийн үлдэгддэл 3.26 их наяд төгрөгт хүрэв. Тухайн сард олгосон зээл өмнөх сараас 1.2 хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.2 хувиар буурсан байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн 98.4 хувь нь төгрөгийн, 1.6 хувь нь гадаад валютын зээл байгаа бөгөөд нийт ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээл 0.6 хувийг эзэлж байна.




* Эх сурвалж Монголбанк

Гадаад худалдаа

Гадаад худалдаа


2015 оны наймдугаар сард худалдааны нийт бараа эргэлт 5798.4 сая ам.доллар, үүнээс экспорт 3251.6 сая ам.доллар, импорт 2546.8 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 704.8 сая ам.долларын ашигтай гарлаа. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 1353 сая ам.доллар буюу 18.9 хувь, үүний дотор импортын хэмжээ 1028.9 сая ам.доллар буюу 28.8 хувиар, экспортын хэмжээ 324.2 сая ам.доллар буюу 9.1 хувиар тус тус буурчээ. Өмнөх оны эхний 8 сард экспорт, импорт тэнцүү гарч, гадаад худалдааны тэнцэл тэг байсан бол 2015 оны эхний 8 сард 704.8 сая ам.долларын ашигтай гарчээ.



* Эх сурвалж УСХ, МБ

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2015 оны 7-р сард гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 99.4 сая ам.долларт хүрлээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 35.5 сая ам.доллар буюу 35.8%-иар, өмнөх сараас 33.8 сая ам.доллар буюу 34%-иар тус тус өслөө. Гадаадын шууд хөрөнгө оруулалтад МУ-аас гадаадруу гаргасан хөрөнгө оруулалт 0.1 сая ам.доллар байсан бол Монгол Улсад 99.6 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ. Сүүлийн дөрвөн сар дарааллан хөрөнгө оруулалт эерэг дүнтэй гарч байгаа билээ.




* Эх сурвалж МонголБанк

Монгол Улсын гадаад өр, зээлжих зэрэглэл

Гадаад өр

2015 оны хоёрдугаар улиралд Засгийн газрын нийт гадаад өр 3.7 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 21.6 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 4.9 хувь (185.7 сая ам.доллар), Улсын нийт гадаад өр 3.6 хувь (777.5 сая ам.доллар)-аар тус тус өссөн байна. Тайлант улиралд нийт Улсын гадаад өрийн 17 хувийг засгийн газрын өр, 9 хувийг Төв банкны өр, 10 хувийг хадгаламжийн байгууллагуудын өр, 16 хувийг бусад салбаруудын өр, 49 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна. Төв банкны нийт өрийн 96 хувийг богино хугацаат, 4 хувийг урт хугацаат өглөг эзэлж байна.



* Эх сурвалж Монголбанк

Засгийн газрын гадаад өрийн 2015-2017 оны төсөөлөл

Тэрбум төгрөг

Үзүүлэлтүүд	2014.09.3 Гүйцэтгэл	2015 он	2016 он	2017 он
ЗГ-ын гадаад зээлийн өр	3,911.50	4,089.20	4,299.10	4,169.30
ЗГ-ын гадаад үнэт цаасны өр	2,760.80	2,625.00	2,550.00	2,490.00
Засгийн газрын баталгаа	2,305.50	2,515.80	2,439.20	1,312.50
Засгийн газрын гадаад өрийн дүн	8,977.80	9,230.00	9,288.30	7,971.80

* Эх сурвалж Сангийн яамнаас гаргадаг тайлан мэдээ

Сарын онцлох үйл явдал

- 08.04** 2015 оны наймдугаар сарын 4-ны УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн төслийг хэлэлцэж баталлаа. Уг хуулийн зорилго нь татварын баазыг тэлэх, хөрөнгө оруулалтын урсгалыг сайжруулах мөн бизнес эрхлэгчдэд шударгаар үйл ажиллагааг явуулах боломжыг нээхэд чиглэгджээ.
- 08.06** Улсын Их Хурлын 2015 оны ээлжит бус чуулганы 8 сарын 6-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын өргөн барьсан “Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүдийг огцруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж 6 сайдыг огцруулав.
- 08.17** Монгол Улсын Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж Өршөөл үзүүлэх хуульд хэсэгчлэн хориг тавилаа. Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хориг тавих шийдвэрийг 8-р сарын 17-ны өдөр УИХ-д хүргүүллээ.

Тойм**2015 оны шинэ хичээлийн жилд төрийн өмчийн их сургуулиудын төлбөр 40 хүртэл хувиар өсжээ.**

Сургалтын төлбөрийг ихэнх сургуулиуд тухайн жилийнхээ инфляцитай уялдуулж нэмдэг бөгөөд үүнийг сургалтын материаллаг бааз сайжруулах, сургуулийн орчинд бүтээн байгуулалт хийх зэргээр тайлбарлажээ. Мөн сургалтын төлбөрийг тухайн жил сургуулийн Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэдэг байна.

Сайд нарыг огцруулав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны Ухнаагийн Хүрэлсүхийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдын үүрэгт ажлаас

Төсвийн байнгын хорооны Жаргалтулгын Эрдэнэбатыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайдын үүрэгт ажлаас

Эдийн засгийн байнгын хорооны Дамдины Цогтбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Барилга, хот байгуулалтын сайдын үүрэгт ажлаас

Эдийн засгийн байнгын хорооны Намхайн Төмөрхүүг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайдын үүрэгт ажлаас

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны Содномын Чинзоригийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хөдөлмөрийн сайдын үүрэгт ажлаас

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны Дуламсүрэнгийн Оюунхоролыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын үүрэгт ажлаас тус тус огцруулав.